

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.10.21

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- S&P 500 индексийн тайлангаа зарласан компаниудын 79% нь 3-р улиралд орлогын таамаглалаа давлаа.
- Газрын тосны үнэ буурсан нь Израил Ираны нефть, хийн дэд бүтцэд довтлох эрсдэл багассантай холбоотой.
- TSM, NFLX хувьцаануудын тайлан сайн гарснаар технологийн компаниуд өндөр өсөөд байна.
- Хятад 800 тэрбум юаниар хөрөнгийн зах зээлээ дэмжих эхний алхмаа хийлээ.
- Хятадын үйлдвэрлэлийн болон жижиглэн худалдааны салбар өсөлт үзүүлэв.

2024 он 10-р сарын 21

Dow Jones	43,275.75
S&P 500	5,864.00
Nasdaq	18,489.5
DAX	19,755.0
FTSE 100	8,405.70
S&P/ASX 200	8,379.5
HANG SENG	20,708.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.04%	0.89%	2.23%	12.87%	30.6%	23.29%
S&P 500	0.06%	0.93%	1.75%	22.75%	39.37%	31.0%
Nasdaq	0.49%	0.35%	1.21%	20.44%	41.21%	34.24%

2024 оны 10 сарын 21-ний 12:00

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.38%	1.46%	1.72%	17.35%	31.67%	26.68%
FTSE 100	-0.12%	1.32%	1.36%	8.01%	13.42%	16.40%

2024 оны 10 сарын 21-ний 12:00

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.4%	0.6%	0.9%	9.1%	13.7%	-4.7%
Hang Seng	-0.75%	-1.93%	-2.7%	20.85%	19.70%	-20.0%

2024 оны 10 сарын 21-ний 12:00

ЗӨВЛӨМЖ

3-р улирлын тайлан зарлагдаж эхэллээ:

Тайлангаас өмнө хувьцаа авах нь компани хүлээлтийг давж чадвал ашиг олох боломжтой боловч орлогын хүлээлтэд хүрээгүй тохиолдолд огцом буурах эрсдэлтэй.

Эрсдэлээс зайлсхийх хүсэлтэй хөрөнгө оруулагчид орлогын тайланг хүлээгээд дараа нь худалдан авалт хийх нь илүү аюулгүй сонголт юм.



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

АНУ-ын хувьцааны зах зээлийн хөдөлгөөн

- S&P 500 индекс эрчимжиж, үл хөдлөх хөрөнгө болон хэрэглээний үйлчилгээний салбарын хувьцаанууд тэргүүлж өссөн байна. Харин эрчим хүчний хувьцаанууд газрын тосны үнэ буурснаас болж буурсан нь Израил Ираны нефть, хийн дэд бүтцэд довтлох эрсдэл багассантай холбоотой.
- Nasdaq Composite индекс долоо хоногийн сүүлээр сэргэсэн бөгөөд Taiwan Semiconductor Manufacturing компанийн тайлангийн үр дүн нь хиймэл оюун ухаантай холбоотой хувьцаануудын сонирхлыг дахин нэмэгдүүлсэн. Netflix зэрэг компаниудын орлогын тайлан мөн хувьцааны өсөлтөд нөлөөлсөн байна.
- Одоогийн байдлаар, S&P 500 индексийн тайлангаа зарласан компаниудын 79% нь 3-р улиралд таамаглаж байсан орлогоосоо давсан үзүүлэлттэй байна. Энэ нь сүүлийн таван жилийн дундаж 77%-иас илүү байгаа юм.

Хэрэглэгчийн зарцуулалт өсөж, үйлдвэрлэл буурлаа

9-р сард АНУ-ын жижиглэн худалдааны борлуулалт 0.4%-иар нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг дэмжих таатай үзүүлэлт болж байна. Энэхүү өсөлт нь 9-р сард 13 салбараас 10 нь борлуулалтаа нэмэгдүүлсэнтэй холбоотой юм. Харин үйлдвэрлэлийн салбарт 0.3%-иар бууралт гарсан нь өмнөх сард өсөлттэй байсан үзүүлэлтээс доогуур гарчээ. Үйлдвэрлэлийн сулралд Франсин, Хелен хар салхи болон Boeing компанийн ажилчдын ажил хаялт голлон нөлөөлсөн байна.

Ажлын байрны нөхцөл

10-р сарын эхэнд анх удаа ажилгүйдлийн тэтгэмж хүссэн өргөдлийн тоо нэмэгдсэн ч, 10-р сарын 12-нд дууссан долоо хоногт 241,000 болж, хүлээгдэж байснаас бага гарсан байна. Гэсэн хэдий ч, олон долоо хоногийн турш ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа хүмүүсийн тоо 9,000-аар нэмэгдэж 1.8 сая болсон нь таамаглаж байснаас бага үзүүлэлттэй байлаа.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын хувьцааны зах зээл дэмжлэг авч өсөв

Хятадын төв банк эдийн засгийн дэмжлэг үзүүлэх шинэ арга хэмжээнүүдийг зарласны дараа Хятадын хувьцааны зах зээл өсөлт үзүүлэв. Үүний үр дүнд Шанхайн нэгдсэн индекс 1.36%-иар, CSI 300 индекс 0.98%-иар нэмэгдсэн бол Хонгконгийн Hang Seng индекс 2.11%-иар буурсан байна.

Хятад 800 тэрбум юаниар хөрөнгийн зах зээлээ дэмжих эхний алхмаа хийлээ

Хятадын Ардын банкнаас (PBOC) эхний ээлжид 800 тэрбум юанийг (112.38 тэрбум ам.доллар) хөрөнгийн зах зээлд нийлүүлэх санхүүгийн хоёр схемийг эхлүүллээ.

Тус банкнаас 9 сарын сүүлээр зарласан хувьцааны своп болон дахин зээлдүүлэх схемийн талаарх мэдээллийг танилцуулсан нь зах зээлийн "тогтвортой хөгжлийг" дэмжих зорилготой юм.

Үйлдвэрлэлийн болон жижиглэн худалдааны салбар өсөлт үзүүлэв

Үйлдвэрлэлийн салбар 9-р сард жилийн дүнгээр 5.4%-иар өссөн нь таамаглаж байснаас өндөр бөгөөд 8-р сарын 4.5%-иас нэмэгджээ. Жижиглэн худалдааны борлуулалт 3.2%-иар өсөж, 8-р сарын 2.1%-ийн өсөлтөөс илүү гарсан байна. Ялангуяа гэр ахуйн цахилгаан хэрэгслийн борлуулалт өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Инфляцын түвшин буурлаа

9-р сард жилийн инфляцын түвшин 0.4% болж, 8-р сарын 0.6%-аас буурч, сүүлийн гурван сарын хамгийн доод түвшинд хүрсэн байна. Цөм инфляц буюу хүнс, эрчим хүчний үнийг хассан инфляц 0.1%-иар өссөн нь 2021 оны 2-р сараас хойших хамгийн бага үзүүлэлт болжээ. Харин үйлдвэрлэгчийн үнийн индекс 2.8%-иар буурсан нь 8-р сарын 1.8%-аас илүү гүнзгий бууралттай байсан юм.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал



ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning October 14, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close		
	KAR		WBA		ASML		tsm		NETFLIX		Comcast
	KAR00000		UnitedHealth Group		Morgan Stanley		TRAVELERS		INTUITIVE SURGICAL		slb
			Interactive Brokers		Abbott		Huntington		WD-40 COMPANY		AMERICAN EXPRESS
			J.B. HUNT		Citizens Financial Group, Inc.		Elevance Health		CROWN		P&G
			citi		US Bancorp		The Blackstone Group		First National Bank		FTI
			charles SCHWAB		First Horizon Financial Services		Texas Capital Bank		MARTEN		First Third Bank
			Johnson & Johnson		PROLOGIS		Infosys		Metropolitan Commercial Bank		ALLY
			PROGRESSIVE		synchro		TRUIST		WAL		Autoliv
			Equifax		OFG Bancorp		INSTEEL		Alpine		REGIONS
			PNC		Discover		IRIDIUM		OCEANFIRST		Simmons Bank
			STATE STREET		First Community Corporation						Acme United Corporation
http://eps.sh/cal										© 2024 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning October 21, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close		
	DYNEX CAPITAL INC.		verizon		BOEING		ups		dexcom		NYCB
	LUFAX		gm		VERTIV		American Airlines		DECKERS		NEW YORK CONSUMER SERVICES INC.
	HBT Financial		3M		AT&T		Nasdaq		Western Digital		COLEGATE-PALMOLIVE
	Kaspi.kz		RTX		Coca-Cola		Southwest		SKECHERS		PIPER SANDLER
			enova		nextera ENERGY		LKQ		EDWARDS		Booz Allen Hamilton
			Baker Hughes		GE Vernova		DARLING		BOYD		SALA
			volaris		ThermoFisher Scientific		Honeywell		KINSALE		CENTENE
			Robert Half		QuantumScape		LIFE TIME		VALE		AON
											WORLD
											WISDOMTREE
											newell BRANDS
http://eps.sh/cal										© 2024 Earnings Whispers	